



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 6 дугаар зүйлийн 6.1, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Чоногол трейд ХХК-ийн гомдолтой эм биобэлдмэлийн хяналтын улсын байцаагчид холбогдох захиргааны хэрэгт хариуцагчаар оролцох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт холбогдох Захиргаа, удирдлагын газрын хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Батбаяр, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Батзориг, Чанарын хяналтын газрын ахлах, Эм, биобэлдмэлийн хяналтын улсын ахлах байцаагч Г.Номин нарыг оролцуулахаар итгэмжлэл олгосугай.

2.Итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Батбаяр, Л.Батзориг, Г.Номин нарт Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг олгож, хянан шийдвэрлэх ажиллагаанд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрыг төлөөлүүлж, оролцуулсугай.

3.Тушаалын хэрэгжилтийг хангах, хяналт тавих, шаардлагатай материалаар ханган ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Намхайноров)-т үүрэг болгосугай.

ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Д.УРАНЗАЯА



142022 01021